

ЖИБЗУНДАМБА ХУТАГТЫН ШАВИЙН ТАХИЛЫН ЦАЙНЫ АЛБАНЫ АСУУДЛЫГ ТОДРУУЛАХ НЬ

Г.БАЯРМАА

Товч агуулга: Халхын шарын шашины тэргүүн Богд Жибзундамба хутагтын харъяат Их шавийн ардууд хутагтын болон харъяа сүм хийдийн зардал хэрэглэлийг гаргах үндсэн үүрэг хүлээдэг байсныг Тахилын цайны алба хэмээн нэрлэдэг байжээ. Энэ өгүүлэлд Богд Жибзундамба хутагтын харъяат шавийг захирах Эрдэнэ шанзудбын яамны үйл ажиллагааны нэг хэсэг Их сангийн үйл ажиллагааны алба оноох, хураан татах асуудлыг тодруулахдаа хутагтад шавь өргөгдөх ардын хөрөнгө чинээний байдал, нийт шавь нарын хөрөнгөнд алба тогтоох ба отог багуудаас хутагтын санд хэчнээн төрлийн алба барьдаг байсныг Монгол Улсын Үндэсний Төв Архивт хадгалагдан байгаа Эрдэнэ шанзудбын яамны данснуудыг ашиглан тодруулахыг хичээсэн болно. Ийнхүү үзхэд Их шавьд харъяат бологсод ихэвчлэн лам хуврага, цөөн тооны мал ахуйтай хүмүүс байхын сацуу Эрдэнэ шанзудбын яамнаас 3 жил дутам явуулах өрх, хүн ам, малын тоо бүртгэл нь Их шавийн ардын өрх, хүн ам, малын тоог бүрэн илэрхийлэх баримт биш харин алба оноох данс бүртгэл хэмээн үзлээ. Мөн энэхүү бүртгэл ёсоор барих Тахилын цайны алба нь шавь болгосодын үндсэн үүрэг төдийгүй албаны нэг төрөл юм. Албыг тахилын цайны алба болон шавь нарын малын ашиг шимээс татах алба хэмээн 2 хэсэгт хуваан алба онуулдаг байжээ. Их сангийн хүчин чадал нь шавь нарын үндсэн хөрөнгө малын тоо толгойноос хамаарч байсан байна.

Түлхүүр үг: Жибзундамба хутагт, Их сан, Эрдэнэ шанзудба, шавь, тахилын цай, сэвэг, сул

Өндөр гэгээн Занабазарыг (1635-1723) Халхын шарын шашины тэргүүнээр өргөмжилсөн тэр цагаас монголын олон ноёд, язгууртан өөрсдийн албат лам, хар ардыг шавь болгон өргөснөөр Их шавийн үүсэл тавигдсан байна. Шавь нар олшрохын хирээр шавийн захиргааг бий болгон харъяат нараа отог, багт хуваан

захирах болжээ. Жибзундамба хутагтад шавь бологсдын үндсэн үүрэг нь хутагтын болон Их шавийн харъяа сүм хийдүүдийн хурал номын хэрэглэлийг бэлтгэн гаргах байв. Энэ тухай Дээрхийн уг эх гэх эх сурвалжид дурьдсанаар, “...олон шавь нар цөм огт алба үгүй гагцхүү Жибзундамба ламын санд алба барьж шарын шашны хэрэглэл гаргасаар иржээ”¹ хэмээн өгүүлсэн байдаг.

Жибзундамба хутагтын шавийн судалгааг анх Д.Цэдэв² хийжээ. Тэрээр хутагтын шавийн үүсэл, эдийн засгийн байдал, албыг тусгайлан судалсан байна. Мөн 1764-1918 оны хоорондох шавь нарын өрх, ам, малыг тоо, 1764-1915 онуудын хутагтын сүргийн тоог анх удаа гарган тавьсан байдаг.

Ц.Насанбалжир³ Жибзундамба хутагтын сангийн тухайлан судалгааг хийсэн. Сангийн үйл ажиллагааг бүхэлд бичсэний дотор шавь нарт алба оноох асуудлыг шавь нарын малын нэг бүрийн тоонд алба онуулдаг байжээ хэмээгээд алба хэрхэн оноох, төрөл зэргийг бичсэнээс шавь нарын хөрөнгө чинээний байдлыг тухайлан авч үзсэнгүй.

З.Нинжбадгар⁴ Жибзундамба хутагтын шавийн захиргаа Эрдэнэ шанзудбын яамны үйл ажиллагааг судлахдаа (XVII-XX зууны эхэн) яамны үйл ажиллагааны нэг хэсэг болох алба хураах асуудлыг Чин улсын үеэр хязгаарлан авч үзсэн боловч тухайн шавь нарын хөрөнгө чинээнд таацуулан хэрхэн алба оноож байсныг авч үзсэнгүй.

Ш.Нацагдорж,⁵ С.Пүрэвжав⁶ нар Монголын нийгмийн байгуулал, сүм хийдийн судалгаа хийхдээ хутагтын шавь нарын асуудлыг хөндөн үзэж алба татах бодлогыг гол болгосон бичжээ.

Хутагтын шавийн судалгаа хийсэн дээрх эрдэмтэд Их сангийн үйл ажиллагаа шавь нараас алба татаж байсныг тодорхой бичсэн боловч энэ алба баригч шавь нар хэдий чинээний хөрөнгө малтай байсан талаар тодорхой зүйлийг судлалгүй орхисон байна. Мөн 1764-1921 оныг хүртэлх 3 жил дутам явуулах шавийн яамны хүн ам, малын данс бүртгэлүүдийг Их шавийн өрх, хүн ам, малын тоо бүртгэл хэмээн үзсэн байна.

¹ *Дээрхийн уг эх*. Тэргүүн дэвтэр. УУНС, Монгол судлал, гар бичмэл номын фонд.

² Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: 1964

³ Насанбалжир, Ц. “Жавзандамба хутагтын сан”, *Түүхийн судлал*, Т- VIII, 1970, 143-153

⁴ Нинжбадгар, З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVIII-XX зууны эхэн)*. Улаанбаатар: 2014

⁵ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978;

Нацагдорж, Ш. *Сум хамжилга шавь ард*. Улаанбаатар: 1972

⁶ Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. Улаанбаатар: 1978

Иймээс энэхүү өгүүлэлд шавь нарын хөрөнгө чинээ, өрх, хүн ам, малын тоо бүртгэл, албаны асуудлыг МУҮТА¹-ын газар хадгалагдан байх Их шавийн Эрдэнэ шанзудбын яамны данс харааг ашиглан

- Шавь өргөгдөх ард хэр хэмжээний хөрөнгөтэй шавьд орж отог, багт хуваагдаж байсан тухай
- Жибзундамба хутагтын шавь нарын хөрөнгөд алба оноох байдал
- Шавь нар хичнээн төрлийн албыг Их санд хэрхэн баривчлаж байсныг тодруулан үзэх болно. Гэхдээ юун түрүүн Их сангийн үүсэл эрхлэх ажлын тухай тодруулах нь зүйтэй болов уу.

Хутагтын их сангийн тухайд

Халхын Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 1639 онд ...5 сүүдэртэй Халхын долоон хошуу бүгдээрээ Ширээ нуур хэмээх газар ширээнээ залж Шар хүрээ хийн гэгээн цол өргөн тахив² хэмээсэн энэ үеэс Монголын олон язуртнууд өөрсдийн хамжилга албатын дотроос лам, хар шавь таслан өгснөөр Их шавийн анхны үүсэл тавигдсан. Үүний зэрэгцээ сүсэгтэн олноос өргөсөн ...мандал даншаг, өргөл барьцын үлэмжхэн эд бараа, эрдэнэсийн ховор нандин зүйлс, олон тооны мал хөрөнгө хуримтлагджээ. Тэр бүгд нийлээд гэгээний зоог шүүс, хувцас, орд өргөө, сүм дугана хурал номын зардал бэлтгэн нийлүүлэх сан аж ахуйг үүсгэжээ.³ Энэ үеэс гэгээнд бараа болох лам нар, бусад ажил эрхлэх хүмүүс буй болсонд 1651 онд Өргөөнийхөө⁴ зохион байгуулалтад өөрчлөлт хийсэн.

Бизьяагийн аймгийн цорж Лувсандондовын зохиосон Өндөр гэгээний намтарг (Занабазарыг хэлж байна-Г.Б.) өгүүлснээр ...Өндөр гэгээний шавдан бат байлгахын тухайд Төвөдөөс гүрэм заслын ном буулгасны дагуу Алтангэрэл судрыг маш олон уншуулсан аж. Тэр үеэд гэгээний гүрэм заслын зүйлийг Гэгээний сангаас гаргаж байсан бөгөөд тэр сан хариуцагч албаны лам нарыг Сангай аймаг хэмээн нэрлэх болжээ. Мөн идээ хоол зоогоор Гэгээнтний лагшин биеийг засаж тордож байсан лам нарыг Зоогой аймаг⁵ хэмээн нэрлэх болжээ. Мөн ...Жасын аймаг нь хүрээ хийд хурал номын зардал бэлтгэх ажлыг⁶ хариуцах үүрэг бүхий болгожээ.

¹ Монгол Улсын Үндэсний Төв Архив (МУҮТА хэмээн товчлох болно).

² Богдын уг эх. УҮНС, Монгол судлал, гар бичмэл номын фонд. 76

³ Насанбалжир, Ц. “Жавзандамба хутагтын сан”, *Түүхийн судлал*, Т- VIII, 1970, 143

⁴ Занабазарыг гэгээн цол өргөн Шар бүсийн орд байгуулсан. Тэрхүү ордыг Богдын өргөө, Хутагтын өргөө хэмээн нэрлэдэг болжээ. Энэхүү өргөө хожим Нийслэл хүрээ болтлоо өргөжсөн.

⁵ Их хүрээний Гучин аймаг. Архивын баримтын эмхтгэл. Улаанбаатар: 2015, 5

⁶ Насанбалжир, Ц. “Жавзандамба хутагтын сан”, *Түүхийн судлал*, Т- VIII, 1970, 143

Хожим Их Хүрээний зохион байгуулалт цэгцэрч аймаг¹ нь лам нарын бүртгэл бүхий хийдийн нэгтгэл болсноор аймгуудын эхэн үеийн үүрэг нь өөрчлөгдөж хоол хүнс, аж ахуйтай холбоотой асуудлыг сан баригч буюу шанзудба² ноёны эрхлэн захирах Эрдэнэ шанзудбын газар мэдэх болжээ.

Сурвалжид энэ тухай мэдээ тодорхойгүй боловч Эрдэнэ шанзудбын албан тушаал хэдүйд буй болсон талаар судлаачид Ө.Сэрээтэр МУҮНС³-ийн гар бичмэлийн фондод байх Эрдэнэ шанзудбын уг эхэд нэр нь дурдагдах *Дагвалхүндэв*⁴-ийг энэхүү тушаалыг 1690 оны сүүлчээс хаших болсон болов уу гэж үзээд, ...*Өндөр гэгээний сан шавь нарыг захирагчийн үүрэг гүйцэтгэж байсан боловч уг тушаалыг түр, бүр хүлээсэн алин болох, эхэлсэн дууссан чухам он цаг нь тодорхой бус байдаг гэж бичжээ*⁵. *Д.Цэдэв 1709 онд гарсан Халх журам хуулийг*⁶ баталсан чуулганд хутагтын шанзудба тэргүүн нарын нэгэнд оруулсан байна⁷ гэж үзжээ.

Харин З.Нинжбадгар ...*Өндөр гэгээн Занабазарыг 1649-1651 онд Түвэдэд анх очиход V Далай лам, IV Банчин-Эрдэнэ нараас түүнд 50 орчим түвэд шавь бараа болгосны дотор Намжил дацангийн ловон Жаюл хамба, Барайбун хийдийн жасын нярав шанзудба тушаалтай хүн байсан мэдээ байдаг*⁸. ...*Очирдара эрхийн ван абшигийг гүн номуудыг хумхын усан юүлэх адил бүртгэж аваад багш, шанзудба, гзбхүй, сойвонгоос ургуудад хүртэл 50-иад тангуд хуврагийг дагуулан Эээр Засагчийн 8-р он цагаагчин модон туулай жил заларч ирсэн*⁹ хэмээсэн сурвалжийн мэдээнүүдийг үндэслэн Энэхүү шанзудба тушаалтай лам 1651 онд монголд ирсэн

¹ Аймаг шашины хурал номын ажлыг эрхлэн явуулдаг анхан шатны газар. Их хүрээ, Гандан хийдэд шавилан суугч лам нарыг тус тус харьяалан захирдаг анхдагч захиргааны байгууллага. Анх 1651 онд Амдуу, Жасын, Сангай, Зоогоо, Хүүхэн ноёны, Дархан эмчийн, Өрлүүдийн хэмээх анхны аймгууд байгуулагдсан бол 1903 онд Эх дагины аймаг байгуулагдсанаар Их хүрээ 30 аймагтай болсон.

² *Шанзудба*: Төвөд хэлний мутрын сан баригч гэсэн үг. Сүм хийд, хутагтын сан, эдийн засгийн асуудлыг эрхлэн мэддэг хүн. Жибзундамба хутагтын шавь нарыг захирагчийг Эрдэнэ шанзудба гэдэг.

³ Монгол улсын Үндэсний Номын Сан (МУҮНС хэмээн товчилно).

⁴ *Хүрээний Эрдэнэ шанзудбын уг эх*. УҮНС, Монгол судлал, гар бичмэл номын фонд.

⁵ Сэрээтэр, Ө. *Монголын Их Хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч*. Улаанбаатар: 1999, 123

⁶ *Халх журам*: 1709 онд зохиогдож 20-р зууны эхэн үе хүртэл хэрэглэгдсэн хууль зүйлийн бичиг. Халхчууд 1691 онд Чин улсын эрхшээлд орсон хэдийч Халхын дотоод асуудал энэ хуулиар зохицуулагдаж байв. Тухайлбал: Эрдэнэ шанзудбын яам нь Их шавийн доторх эрүү, иргэний хэргийг энэ хууль ёсоор шийтгэж байсан.

⁷ Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: 1964, 31

⁸ Нинжбадгар, З. *Жибзундамба хутагтын шавийн захиргаа (XVIII-XX зууны эхэн)*. Улаанбаатар: 2014, 32

⁹ *Богд Жибзундамба хутагтын анхан төрлийн нэр оршвой орон дацан анхан байгуулсныг бичсэн буйнаар бурханы шашин өнө үүрд орших болтугай*. Илтгэл шастир. Улаанбаатар: 2006, 416

нь энэ албан тушаалын эхлэл байсан болов уу гээд 1723 онд Манжийн хаанаас уг албан тушаалыг баталгаажуулж шавь нарыг хэргийг эрхлэх Эрдэнэ шанзудбын тамга олгосон гэсэнтэй санал нэг байна.

Дээрхи баримт таамгуудаас үзвэл хутагт 1651 онд хамт ирсэн шанзудбад сангийн хэргээ шууд эрхлэн мэдүүлээгүй. Сан хариуцагч лам нарыг Сангай аймагт хамааруулж байгаад 1690-1700 оны үед шанзудбын албан тушаалыг бий болгож 1709 он гэхэд эрх мэдэл бүхий албан тушаал болсон нь харагдаж байна. 1723 онд Иньчэнь /1678-1735/ хаан: “...шанзудба Доржванчигт Шашныг мандуулагч Жибзундамба бламын Хүрээний хэргийг ялган бүгд шавь нарыг захирагч Эрдэнэ шанзудбын тамга хэмээх гуулин тамга шагнасан”¹ олгосон байдаг.

1764 онд Тэнгэрийн тэтгэсэн хаан Эрдэнэ шанзудбын тушаалд Гомбодоржийг томилсон зарлигт: “...Шанзудбын тушаал хэмээгч чухал, Хутагтын элдэв хэргийг дааж шийтгэх хүн ...Богд эзэн гэгээнээр айлдаж Гомбодорж чамайг сайн хэмээн шанзудба тавьж Хутагтын шавь нар, сан, сүрэг болон хамаг хэргийг захиргав”² хэмээсэн баримтууд байдаг. Хутагтын санг гадаад, дотоод хэмээн хуваана.

- Дотоод сан хутагтын ордны доторхи бурхан тахилын хэрэгсэл, үнэт эрдэнэс, торго дурдан зэрэг эд таваарыг хадгалах, мандал даншгийн харамж, өргөл барьц, бэлэг сэлт хүлээн авах, орд сүмд хэрэглэх зүйлийг бэлтгэх ажлыг хариуцна. Дотроо шадар сан хэмээх Хутагтын ордны өдөр тутам хэрэглэх хувцас, ямба ёслолын зүйлийг хариуцан ажилдаг байв.
- Гадаад сан буюу Их сан нь хутагтын аж ахуй, санхүүгийн ажлыг эрхлэн мэддэг. Сүрэг мал адуулах үржүүлэх, арилжаа худалдаа хийх, жин тээвэр хөдөлгөх, тариа тариулах, хадлан хадах, мөнгө, цай бараа таваар зээлдэн авах, зээлийг төлөх, сангийн орлого зарлагын данс тооцоо хийх, хөрөнгө хогшил бүртгэх, сан шавийн дотор зарцуулах цаасан мөнгө гаргах, тариалан хадлангийн газар түрээслэх, хандив эрэх, хутагтын бүх зоог, хүрээ хийдийн хурал номын зардал нийлүүлэх, шавь нарт алба татвар оноох, алба татвар хураах ажлуудыг эрхлэн мэдэж байжээ. Их сангийн дэргэд үржүүлэх сан ажиллана. Аймаг, хошуу, отог, хувь хүмүүст мөнгө зээлдүүлэн хүү үржүүлж мөнгө цайг хүүгийн хамт хураан авах зэрэг бүр ажлыг Эрдэнэ шанзудбын газар эрхэлдэг байжээ.

Их сангийн ажлуудын дотроос алба оноох, алба хураах ажлуудыг сонгон

¹ МУУТА. М-85, Д-1, Хн-48.

² Нинжбадгар, З. *Живзундамба хутагтын шавийн захиргаа (XVIII-XX зууны эхэн)*. Улаанбаатар: 2014, 46

авсан болно. Алба оноох асуудлын цаана шавь нарын амьжиргааны түвшин, хөрөнгө чинээний байдал тодрон харагдах билээ. Энэхүү асуудлыг авч үзэхдээ Жибзундамба хутагтад шавь болон өргөгдөх ардын хөрөнгө чинээний байдлыг эхлэн тодруулах нь зөв болов уу.

Шавь өргөгдсөн ардын хөрөнгө чинээний байдал

Монголын язгууртнууд өөрсдийн хамжлага нараас шавь болгон өргөх явдал анхдугаар Богдоос VIII Богдын үе хүртэл тасралтгүй үргэлжилж байсныг илтгэх олон баримтууд МУУТА-г хадгалагдан байна. Тэдгээрийг түүхэн зүйн зарчмыг баримтлан зарим нэгэн зүйлийг тодруулваас, Тэнгэрийг тэтгэсэн 47 оны (1782) Засаг, улсад туслагч гүн Гончигдоржийн бичигт:” ... *ноднин жил (1781) Дээрхийн гэгээн заларч ирэхэд Да сэцэн ханы Хэрлэний Цагаан чулуутын газар аймгаар Данииг өргөж үүнд тохиолдсон засаг бүрээс нижгээд өрх хүнийг шавь болгон өргөө*”¹ гээд олон засгаас шавь өргөсөн тухай баримтыг үзвээс 1639 онд үүсгэл нь тавигдсан Богдын хамжлага шавь ардын тоо жилээс жилд өсч, улмаар Халхын ноёдууд бөөнөөрөө шавь өргөх болжээ.

Мөн 1837 оны нэгэн баримтад: “... гагцхүү Жибзундамба хутагт болвоос зарлигаар тусгайлан Халхын дөрвөн аймагт тахиулсан ихээхэн блам бусад бага сага хутагт нарт адилтгаваас болох үгүй. Хутагт угаас дагаар ирсэн шавь үгүй. Анхан дүрээс эдүгээ болтол олон Монгол хан, ван, засаг тайж нар шарын шашныг эрхэмлэж ном хурлын хэрэглэлд туслуулахаар өөр өөрийн хамжлага албат, хошууны ардын дотроос дуртайг нь үзэж шавь болгосоор ирэв”² хэмээн шавь нар олиширч буйг өгүүлжээ.

Эдгээр шавь болсон ардын хөрөнгө чинээний байдлыг тодруулахдаа Монгол Улсын Архивт байгаа 1739-1809 оны хоорондох 15 хадгаламжийн нэгж, 171 нугалбар³ баримтыг шинжлэн үзсэн бөлгөө.

Шавь өргөгдсөн ардын хөрөнгө чинээний асуудлыг анх Д.Цэдэв авч үзсэн тэрээр 1719-1811 онуудын нэгдсэн тэмдэглэл данс байна гээд:” ...Халх дөрвөн аймгийн хаад, засаг, ноёд, тайж нар, Өвөр Монгол, Авга зэрэг олон засгаас 1,2,3,4-р Богд Жавзандамба хутагт нарт 17100 хүн ам, 3780 гаруй өрх айлыг 50568 бод мал, 126612 бог малын хамт шавь болгон өргөжээ⁴ гээд аймаг тус бүрээр нь хүснэгтээр

¹ МУУТА. ХМ-85, Д-2, ХН-47, нугалбар 3.

² Нинжбадгар, З. *Живзундамба хутагтын шавийн захиргаа (XVIII-XX зууны эхэн)*. Улаанбаатар: 2014, 15

³ МУУТА. М-85, Д-2, Хн-1083, 55, 826, 18, 17, 32, 3, 47, 11, 12, 9, 8, 345, 455, 230, 3.

⁴ Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: 1964, 25

харуулсан байна. Тухайлбал, ...Түшээт хан аймгаас хувраг 5336, хар ард 1558, эмэгтэй ба хүүхэд 5890, бүх ам 12784, өрх 2116, бод мал 24723, бог мал 65257¹ гэсэн тоо баримтыг гарган Шавьд өргөгдсөн ардууд хөрөнгө чинээний хувьд ихээхэн ядуу хүмүүс байсан байна гэж дүгнэсэн ба 1811 оноос хойш шавь болсон хүмүүсийн нэгдсэн данс олдохгүй байна хэмээн бичжээ.

Миний бие судлаач Д.Цэдэвийн үзсэн нэгтгэсэн баримтыг олж үзэж чадсангүй. Харин нэг цаг үеийн 15 хадгаламжийн нэгжийн, 171 баримт дээр ажиллаа. Тухайлбал: Тэнгэрийн тэтгэсний 55 оны (1781) 15 нугалбартай хадгаламжийн нэгжид өрх 11, өрх үгүй ганц бие хувраг 2, эмэгтэй 1, нийт ам 39, бод 378, бог 1005 малтай шавьд орсон байна. Жишээ нь: ...Чуулганы тэргүүн Далай Сэцэн хан таны бичиг мэдүүлэх нь манай хошууны гүн Цэдэнжав эцэг гүн гэлэнгийн буянд өргөх гэсэн хуврага Чүлтэмийн дүү хуврагатай 2 ам, 1 өрх, 20 бод, 50 хонь, хар Бяцханхүүгийн 5 ам, 1 өрх 15 бод, 40 хонийн хамт² гэх мэт баримтууд байна.

Дээрх 171 нугалбарт ам 632, амын тоо тодорхойгүй 62 нугалбар, өрх 179, өрхийн тоо тодорхойгүй 73, бод мал 3294, бог мал 8737 нийт мал 12031, малын тоо тодорхойгүй 57 байна.

Ам болон өрхийн тоо тодорхойгүй байгаа шалтгаан нь ганц бие лам нар шавь орохтой холбоотой, амын тоо тодорхой биш хэмээсэн 62 нугалбарын 34-т ганц бие хувраг, үлдсэн хэсэгт нь 2 өрхийг ам бүлийн хамт гэх мэтээр тодорхойгүй байдлаар бичсэн байна. Тухайлбал: *Хэрлэн барс хотын чуулган дарга Сэцэн хан манай хошууны ганц бие лам Дэнзэн дээрхид шавь болье хэмээн үнэн сүсгээр гуйн мэдүүлсэн 7 бодтой шавь болгон өргөснийг батлан мэдүүлэв³* гэсэнтэй ижил утгатай олон баримтууд байна.

Ганц биеэр лам шавь орох нь ...уул ламын ёсонд гэлэн хүн гэрээс гарч аглаг хийдэд шавилан сууж ном унших, тэдэнд өөрийн гэх гэр орон, аж ахуй, гэргий хүүхэд, эд мал тэргүүтэн үгүй байх ёстой⁴ хэмээсэн ёсыг дагаж ямар нэг ам, өрх, амьжиргааны мал үгүй шавьд захирагдаж байсан байж болох. Их шавийн нэг онцлог нь ламаар толгойлуулсан гэр бүлийг өрхийн тоонд тооцдоггүй байсан нь дээрх ламын ёстой холбоотой байсных болох уу.

¹ Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: 1964, 26

² МУУТА. М-85, Д-2, ХН-47, 9-нуг.

³ МУУТА. М-85, Д-2, ХН-455, 13 нуг.

⁴ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 196

Эдгээр шавь орохыг илэрхийлсэн 236 баримт байгаагаас малын тоо толгой нь тодорхой 179 өрхийн бод, бог нийлсэн 12031 мал байна.

Шавь болохдоо амь гэжээх хичээн тооны малтай ирснийг тодруулбаас дээд тал нь 400 гарах малтай байхаас огт малгүй ирсэн өрх, ганц бие лам, хар хүн цөөнгүй байна. Энд 400 гаран малтай 4 өрх, 300 гаран малтай 2, 200-9, 100-16, 90-5, 80-1, 70-4, 60-7, 50-7, 50-7, 40-12, 30-18, 20-20, 10-гаран малтай 19, 10-аас доош малтай 13, малын тоо тодорхойгүй 57 гэсэн дүн гарсан. Эндээс харвал 100-дээш малтай 31 өрх, 90-50 гаран малтай 24 өрх, 40-өөс доош малтай 82 өрх, огт малгүй амжиргааны малтай гэсэн 57 бичиг байгаагаас үзвэл хутагтад шавь бологсодын амжиргааны түвшин муу байжээ. Энд тоологдсон нийт 236 өрх айл, ганц бие лам гэж шавьд захирагдсан ардын 60% хувь нь 50-доош малтай ядуу өрхүүд байна.

Шавьд захирагдсан эдгээр ардууд шавийн захиргаа Эрдэнэ шанзудбын яамнаа бүртгэгдэж, Их шавийн засаг захиргааны зохион байгуулалт отог, багуудад хувиарлагдан Жибзундамба хутагтын болон харьяа сүм хийдийн хурал номын зардал, шавийн захиргааны зардлыг гаргах үүрэг хүлээдэг байжээ. Сурвалжид: *Хар шавь болвоос хэвээр дөрвөн аймгийн зэрэг газраа хольцолдон сууж Хүрээний санд алба барьж шарын шашны хэрэглэл гаргамуй¹ хэмээсэн ёсоор үндсэн хөрөнгө болох малын хөлдөө таацуулан Тахилын цайны албыг Их санд барих үүрэг хүлээдэг байжээ.*

Ш.Нацагдорж албыг оногдуулахдаа “... өрхийн хөрөнгийн доод хэмжээг 20 бод буюу 50 цайгаар тогтоодог”² гэж тэмдэглэжээ. Цай нь Жавзандамба хутагтын сангаас шавийн ардын авах татварын нэгж хэмжээ³ юм. Хятадын нэг зузаан хатуу цайг 60 шар цайд тооцох ба 800 шар цай нь 13 хатуу цайтай тэнцдэг⁴-ийг 1 сэвэг цай, 800-д үл хүрэхийг сул цай гэх ба отгийн ардын малыг сэвэг сул цайд дүйцүүлэн албаа тогтоодог байв.

Шар цайг малд буулган бодвол: Тэнгэрийг тэтгэсэний 50 (1785) онд Жибзундамба хутагт шавь ардын адуу, үхэр бүрт 4, тэмээ нэг бүрт 6, хонь бүрт 1 шар цайны хөлөөр алба оногдуулан⁵ байсан бол 1786 онд шавь нарын барьдаг тахилын цайнд хувь нэмэгдүүлэн бодож тэмээ бүрт 8 шар цай, адуу, үхэр бүрт 5

¹ Дээрхийн уг эх. Гутгаар дэвтэр: МУНҮС, Монгол судлал, гар бичмэл номын фонд.

² Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 206

³ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 206

⁴ Чимэд, Ө. *Их хүрээний сүм хийдийн мөнгө хүүлэлийн тухай*. Улаанбаатар: 1958, 5

⁵ Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. Улаанбаатар: 1978, 195

шар цай хонь бүрт нэг цай хугасыг нэмж¹ байжээ. XX зууны эхээр тодорхой бус ч 10 шар цай 1 тэмээ, 8 шар цай нижгээд толгой үхэр, адуу, 2 шар цай 1 толгой хоньтой тэнцэж² байв хэмээн өмнөх судлаачид бичиж үлдээжээ. Үүнээс үзэхэд өргөх зүйлийн тоо жилээс жилд өсч байсан нь зарим талаар үнийн ханштай холбогдоно.

Албын доод хэмжээ 50 цай бол 1785 оны ханшаар 50 хоньтой өрх эсвэл 30 хонь, 2 морь, 3 үхэртэй өрхийг алба барих чадвар бүхий гэж үзнэ. Тухайлбал: 1782 оны нэгэн баримтыг жишээ болгон үзлээ. Малын хөлийг 1785 оны ханшаар бодсон болно. Олонхи нугалбарт тэмээ, адуу, үхрийг бод гэж бичсэн байдаг нь бодит тоо гаргах боломжийг хааж байгаа ч тэмээг үхэр, адууны ханшаар бодъё. *Тэнгэрийг тэтгэсний 47 (1782) оны ...Хан уулын чуулган дэд дарга засаг төрийн жүн ван агсан Цэвээнжавын тамгийн хэргийг шийтгэгч туслагчийн бичиг манай хошууны дөрөвдүгээр зэрэг тайж Цэвээн мэдүүлэх нь хойтын авралыг хүсэж хүү хуврага Лувсаныг хамжлага 3 өрхийн хүнтэй шавь болгон өргөх тойн Лувсан өрх 1, ам 5, бод 28-д адуу 8, тэмээ 2, үхэр 18, хонь 60, Мөнх өрх 1, ам 3, адуу 2, үхэр 8, хонь 60, Цэвээн өрх 1, ам 7, адуу 20, үхэр 13, хонь 20 үүнийг Цэдэн Аврагын отогт отоглуулав³ гэсэн бичигт ---Лувсан 28 адуу 112 шар цай, 2 тэмээ 12 шар цай, 18 үхэр 72 шар цай, 60 хонь 60 шар цай нийт 256 шар цай буюу 256 сул цай --- Мөнх 2 адуу 8 шар цай, 8 үхэр 32 шар цай, 60 хонь 60 шар цай нийт 100 сул цай ---Цэвээн 20 адуу 80 шар цай, 13 үхэр 52 шар цай, 20 хонь 20 шар цай нийт 152 сул цайны хөрөнгөтэй. Эдгээр 3 өрх 508 сул цайны хөрөнгөтэй ба энэхүү хөрөнгө малынхаа тодорхой хувийг тахилын цайны алба болгон барихыг хамт бусад албыг төлөх үүрэг хүлээсэн байна.*

Дээрхи шавь өргөгдсөн ардын 40 хувь нь хутагтын санд алба барих бол, үлдсэн 60 хувь нь алба төлөх чадвар үгүй ардууд шавьд захирагдсан байна гэж үзэж болно. Эдгээр ...Засаг Цэвээнжав миний хошууны зайсан надад мэдүүлэх нь хуврага хүүгээ дээрхийн даншигт зориулан 2 бод, 10 богтой өргөө⁴ гэх мэт хөрөнгө мал цөөн, огт малгүй ардуудыг хутагтын сангаас дэмжин тэтгэж малжуулан амьжиргааг нь сайжруулдаг байжээ. Эрдэнэ шанзудба Дамчойравжаагийн нэгэн бичигт: “...Жибзундамба хутагт хэмээгч олон халхын ардын тахисан лам язгуураас аливаа үгээгүй ядуу ард чин үнэнээр ирж, ирсэн цөм хүнс хувцас

¹ Пүрэвжав, С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. Улаанбаатар: 1978, 196

² Нацагдорж, Ш. Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/. Улаанбаатар: 1978, 226

³ МУУТА. ХМ-85, Д-2, Хн-47, нугалбар 21.

⁴ МУУТА. ХМ-85, Д-2, ХН-9, нугалбар 22.

зэрэг юм тусламой. Олон газрын үгээгүй ядуу ард турж эцэж цагаачлан ирээд хутагтын санд тэжээлгэн шавь нарын дотор удтал хэрж явсаар тэнхэрсэн нь буй...”¹ хэмээсэн бол “...эдгээр ядууст сангаас жил бүр хувцас, цай (мөнгө) олгон тэжээж тэдгээрийг хогшсоны дараа гурван жилд нэг удаа малын тоолж тэдний нэг ам тутам нэг бод таван хонь гаргаж үлдсэн бусад малд алба ноогдуулдаг”² гэж бичсэнээс үзвэл Богдын сан нь ядуу хоосон хүмүүст амьжиргаа залгуулах мал таслан өгч ажил олгогч болон ажилдаг байжээ. Харин тэдгээр хүмүүс малжин ...50 цайнаас дээш өсвөл тахилын цайны алба өгдөг³ үүнийг ...сан сүргээс хүмүүжүүлэх...⁴ гэдэг хэмээн Ш.Нацагдорж бичиж үлдээсэн байна.

Жибзундамба хутагтын сангийн хөрөнгө мал сүрэг сүсэгтэн олны өргөл барьцаас бүрэлдэн байсан ч эргээд ядуу хоосон хүмүүст ажлын байр амьжиргааны эх үндэс нь болж байжээ.

Ц.Насанбалжир, Д.Цэдэв нар Жибзундамба хутагтын 1773-1924 оныг хүртэл мал сүргийн тоог мал тус бүрээр нь гарган тавьсан билээ. Дараах 4 оноор жишээ авлаа.

Хүснэгт 1.⁵

Он	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Нийт сүрэг
1773	19988	1591	4688	64986	91253
1833	30164	3025	2602	36897	72688
1900	8243	191	159	22566	31159
1918	2689	247	564	15473	18973

Эдгээр мал сүрэг нь үржил төл, өргөл барьцаар өсөж байвч зарим үед өвчин тахал, ган зуд, дээрэм тонуул, сүм хийд шинээр бариж байгуулахад ... Шаравпэлжээлин, Гунгаадэжидлин, Пандлин сүм хурал шинээр байгуулж сүрэг малаас олон тооны мал таслан тэдгээр сүмийн сүрэг болгосон⁶ зэрэг шалтгаануудаар хорогдож цөөрч байжээ. Хутагтын мал сүргийг ...хариулах алба бол шавь нарын биеэр гүйцэтгэх алба ...Богдын сүргийг их шавийн 1000 илүү өрх хариулж байв хэмээсэн байна. Их сангаас гар хоосон хүмүүст ...тэдэнд мал аж

¹ ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Түүхийн баримт, мэдээллийн төв. Ф-2, Т-1, Хн-693

² Нацагдорж, Ш. Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/. Улаанбаатар: 1978, 206

³ Нацагдорж, Ш. Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/. Улаанбаатар: 1978, 228

⁴ Нацагдорж, Ш. Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/. Улаанбаатар: 1978, 228

⁵ Насанбалжир, Ц. “Жавзандамба хутагтын сан”, Түүхийн судлал, Т- VIII, 1970,145

⁶ Насанбалжир, Ц. “Жавзандамба хутагтын сан”, Түүхийн судлал, Т- VIII, 1970, 145

ахуй өгч¹ малжисны дараа албаа оноодог байжээ. Гэхдээ энэ сүрэг малыг дан ганц хоосон ядуу хүмүүсээр маллуулж байсан гэж үзэж болохгүй.

Ер нь тухайн цаг үед Жибзундамба хутагтын харьяат шавь болох нь ардуудад олон давуу талтай байсан гэж хэлж болно. Үүнд:

1. Сүсэг бишрэлийн хувьд хутагтын шавь болох нь сэтгэл зүйд таатай.

2. Хутагтын шавь болсноор улсын албанд үл оролцож, ингэснээр тухайн шавь ардын амь амьжиргаанд таатай нөлөө үзүүлэх боломж зарим талаар бүрэлдсэн.

3. Ядуу хоосон ардуудын хувьд хутагтын Их сан, харьяа сүм хийд ажил олгогч болж байжээ гэж үзэж болох юм. Энд: Ядуу хоосон ардыг хутагтын сангаас малжуулах, Их шавийн харьяа сүм хийдийн жасын малыг маллах, хүрээ хийдийн газар ирэн хар бор ажил хийх, их сангийн тарианы албанд ажиллах зэрэг.

4. Шавь бологсад өөрийн төрсөн нутаг, идээшин дассан газартаа мал аж ахуйгаа эрхлэх таатай нөхцлөөр хангагдсан зэрэг нь Их шавийн харьяат болохын давуу талууд байжээ гэж үзэж болно.

Их шавийн отог, баг ба алба оноох тухайд

Жибзундамба хутагтын харьяа шавь нар тухайлан олгосон газар үгүй, урьд аль аймаг хошууны нутагт байсан, тэр нутагтаа хэвээр отог, баг болон хуваагдаж суудаг байв. ...*Тэнгэрийг тэтгэсний 37-р он (1772) онд зарлигаар хязгаар дахиныг тогтоогч жанжин, хэтэрхий баатар ван, амбан ван У ... Халхын хан, ван бэйл, бэйс гүн, засаг нар Ширээт цагаан нуурын газарт чуулган нийлэхэд Жавзандамба хутагтын шавь нарыг хуучин ёсоор дөрвөн аймгийн дотор нийгэмчлэн нутаглуулъя хэмээн тогтоон шийтгэсэн² ний дагуу ... хутагтын харьяат шавь нараас Сэцэн ханы зэрэг 17 хошуунд их, бага бүгд 30 илүү отог багын ард нутаглан суух нь угаас цэс бүхий боловч хаяа салж нийлэх зүйл буй учир одоо чухам аль аль хошуунд ямар нэртэй дарга шүүлэнгийн захирах ард нутаглан буй зэргийг нийлэн хянав³ хэмээсэн баримтад 30 илүү отог, багыг жагсаан бичжээ. Энд: "... Сэцэн хан, засаг Мишигдорж нарын хоёр хошуунд дарга шүүлэнг Цогдорж, Шагдар нарын багын ардууд Лувсанцэрэний отог нутаглана"⁴ гэх мэтээр бичсэн байна. Шавь болсон ардыг харьяат отог багт захируулахдаа ... *Хэрлэн барс хотын чуулган дарга**

¹ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 228

² Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: 1964, 29

³ МУУТА.ХМ-85, Д-2, Хн-1057, нугалбар 1.

⁴ МУУТА.ХМ-85, Д-2, Хн-1057, нугалбар 1.

Сэцэн хан манай хошууны ганц бие лам Дэнзэн Дээрхид шавь болъе хэмээсэнд Хэрлэний дарга Дашдондовын отог. ¹*Сэцэн хан аймгийн засаг гүн Тунгалагын хошуунаас өргөсөн ардыг ... эдгээр улс Эрдэнэ сэцэн ноёны садан болох тул мөн баруун отог захирахаас гадна Цэндгомбыг зайсан Цэнджавын өрх амын дор нэмэх² гэх зэргээр захируулж, отог багт дансалж авдаг байжээ.*

1921 оны байдлаар Их шавийн отог баг Халх дөрвөн аймгийн ...Сэцэн хан аймгийн 14 хошуунд 51 отог баг, Түшээт хан аймаг 17 хошуунд 121 отог баг, Засагт хан аймаг 3 хошуу 6 отог, Сайн ноён хан аймаг 6 хошуу 8 отог баг, мөн Хатгалбум, Бэлдэс Цагаанбулан Агар 4 харуулын гадна суух 2 отог \Дархад шавь, дархадын хойд, баруун\, Хөвсгөл нуурын Урианхайн газар нутаглах 1 отог³ нийт 160 отог, 29 баг тархан нутаглаж байсан байна.

Ийнхүү Халх дөрвөн аймагт тархан суусан Богдын шавь нар тухайн хошууны захиргаанд захирагдахгүй, харин Их Шавийн яамандаа бүртгэлтэй байдаг байсан бөгөөд энд дурьдаж буй отог нь иргэний отгоос ихэд ялгаатай юм. Отгийг дотор нь их, бага хэмээн 2 хуваадаг. Эхэн үедээ 12, дараа 17, XX зууны эхэн үед 19, 1918 оны Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт 30 их отогтой хэмээн хуульчлан заасан боловч 1918, 1921 оныг Их шавийн данснуудад 19 их отгийн бүртгэл байдаг. Их отгуудаас гадна нэр бүхий 120-160 бага отог болон хуваагдан байв.

1924 оны засаг захиргааны шинэчлэлээр Их шавийн отгуудын тоог нэгтгэн 82 хуваасан байна. Отгийг зайсан⁴ дарга, багийг шүүлэнгэ⁵ захиран мэддэг байв. Жишээ нь: *Баруун хүрээний дарга Санжийн отог, Хэрлэний шүүлэнг Мөрдэндэв* ⁶ отог зэргээр нэрлэж байжээ.

Эдгээр отог багын ардуудыг Эрдэнэ шанзудбын яамнаас 3 жил дутам хуврага, өрх, ам, мал сүргийн тооллого хийн малын хөлд таацуулан алба оноодог байв.

Тооллого бүртгэлийг Амын тоо, Өрх, Хувраг, Тэмээ, Адуу, Үхэр, Хонь, Сэвэг, Сул гэсэн асуулгаар явуулдаг байв. Тухайлбал: *Баруун хүрээ Санжийн отог 157 нэр бүхий алба баригчтай. Нийт : хуврага 211, өрх 100, ам 1016, тэмээ 291, адуу*

¹ МУУТА.ХМ-85, Д-2, Хн-455, нугалбар 14.

² МУУТА.ХМ-85, Д-2, Хн-1083, нугалбар 13.

³ МУУТА.Х-179, Д-2, Хн-31.

⁴ *Зайсан*: Их шавийн засаг захиргаа отог юм. Ойролцоо нутагтай хэсэг айлыг нэг отог болгон зайсан даргаар захируулдаг байв. Жишээ нь: Баруун хүрээний отгийн зайсан дарга Санж, Тунгалаг билэгт хутагтын отгийн дарга Шагдар гэх мэт.

⁵ *Шүүлэнгэ*: Отгийн даргийн дараа орох албан тушаал юм. Отгийн адил бие даасан жижиг захиргаа багийг шүүлэнг захирдаг байсан. Орхоны шүүлэнг Ишсоном, Хотгойдын шүүлэнг Балдан гэх мэт.

⁶ МУУТА.А-74, Д-1, Хн-314.

1438, үхэр 535, хонь 3686, сэвэг 27, сул 470 хэмээн бүртгүүлжээ. Үүнээс хуврага Санж --- хувраг 4, өрх 0, ам 8, тэмээ 41, адуу 266, үхэр 32, хонь 154, сэвэг 3, сул 105¹ гэх мэт бүртгэл хийнэ. Хутагтын шавийн олон оны тоо бүртгэл данс байх боловч энд Сэргэн мандсан Монгол улсын² Их шавийн хүн ам, өрх, малын тоо бүртгэлүүдийг жишээ болгон авч үзлээ.

Хүснэгт 2. Их шавийн хүн ам, малын хураангуй³

Он	Нийт отог	Өрх	Хуврага	Ам	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Нийт мал тоо
1912	140	6078	16105	36668	33311	4097	30136	16746	84290
1915	154	6654	16954	38645	25036	3697	21137	103019	152889
1918	162	8833	21180	49878	34440	6186	29743	131551	201920
1918	шинэ 18	1891	2723	8290	1590	262	1355	6196	9403
1918	нийт 180	10724	23903	58168	36030	6448	31078	137747	211303
1921	149	6335	16334	36623	10953	1589	9417	34149	56108
1924	82	13449	24595	86631	186671	31715	246247	1218330	1682963

Эдгээр тоо бүртгэлүүдээс отгуудын нэмэгдэл, хасагдлыг авч үзэе.

Монголчууд туурга тусгаар улсаа байгуулсны дараа Богд хааны харьяа Их шавьд Ар,Өвөр Монгол, Тагна Урианхай нь олон хошуудаас шавь өргөх явдал их гарсан. Тухайлбал: Эрдэнэ шанзудбын яамны нэгэн бичигт: *...энэ завсар Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгаас манай шавьд шилжүүлэн захирсан Ноён ламын шавь сум, Асууд сум, Сөнөд зүүн засаг ван Магсаржаваас шавь болгон өргөсөн Цагаан овооны Буянаар ивээгч сүмийн шавь нар Дарьгангын таван гараас өргөсөн шавь нар бас Манай гадаад Монголын төрийг дагаж харьяат шавьд хавсарган захируулсан*⁴ гэх зэргээр олон засаг хошуудаас шавь өргөж байсан юм. Энэ үзэгдэл 1915 оныг хүртэл тасралтгүй үргэлжилсэн боловч Хиагтын 3 улсын гэрээ⁵-ний дараа Өвөр Монголын олон хошуудаас шавь өргөх явдал саарсан гэж үзэж болно. Шавийн захиргаанд орохоо илэрхийлсэн зарим ардууд нутаг буцсан тохиолдол цөөнгүй. Тухайлбал, *нэгэн аймгийн Алтай урианхайн сайд гүн Галсанжаваас*

¹ МУУТА.А-74, Д-1, Хн-314.

² Монголчууд 1911 онд Чин улсаас салан тусгаарлаж, шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагтыг хаан ширээнээ залж тусгаар улс болсон.

³ МУУТА. А-74, Д-1, Хн-48, А-74, Д-1, Хн-327, А-74, Д-1, Хн-510, А-74, Д-1, Хн-509, А-74, Д-1, Хн-663, Х-179, Д-2, Хн-163.

⁴ МУУТА. ХА-74, Д-1, Хн-1094, нугалбар 4.

⁵ Ар Монгол 1911 онд туурга тусгаар улс болсныг үл хүлээн зөвшөөрсөн Хаант Орос, Дундад Иргэн улсууд 1913 онд Монголыг Хятадын эзэн эрхийн дор автономит улс болгохоор тогтож, 1915 онд Хиагт хотноо гурван улсын гэрээ хийж, Монгол улсад өмнө тохирсон хэлэлцээрийн үзэл санааг тулган хүлээлгэж Автонимт улс болгосон.

шавьд батлан өргөсөн тайж Доржпалам нарын өрх 30 ам бүлийн хамтаар цөм уул хошуунд нүүж буцсан¹ гэх олон баримтууд үлджээ. Эдгээр шавь болон үлдсэн ардыг отогт хуваан захируулж, 1918 оны тоо бүртгэлд 18 шинэ отгийг нэмэн байгуулж алба оноосон байдаг. Тухайлбал: Хуучдын хамба зайсан дарга Шарудын отог хуврага 222, өрх 107, ам 556, тэмээ 1, адуу 29, үхэр 39, хонь 9, Шинэ Баргын зайсан дарга Мишиг отог хуврага 97, өрх 79, ам 383, тэмээ 6, адуу 34, үхэр 30, хонь 276² зэрэг болно. Дагаар ирж шавь бологсодын ихэнх нь шавь үлдсэн байдаг. 1924 оны нэгэн баримтад: Хан Хэнтий уулын аймгийн Сэцэн ван Гомбосүрэнгийн нутаг Баянсайр, хэмээх зэрэг газраар нутаглан суудаг Асуудын Муж Ууд хэмээх 2 отгийн ард нар хэдүйгээс нааш хамтран нутагласаар ирсэн тул тэдний 3 отгийн ард нар завсарт санаа нийлэлцсэн нь ёсоор болгож хавсарган захируулахад Асууд отгийн өрх 52, Муж отгийн өрх 20, Ууд отгийн өрх 40 болсныг 3 баг болго³ гэсэн баримтуудаас харж болно.

Халхын олон засаг хошуудаас Дээрхид (Жибзундамба-Г.Б.) шавь өргөх явдал их байсны дээр ноёдуудаас хамжилга албатын хамт бөөнөөр шавь орох явдал энэ үе нэлээдгүй гарсан байдаг. Жишээ нь: ...Сайн ноён хан аймгийн хошооч мэргэн бэйс Ядамжавын хошууны тойн Гунгаажанцаныг хамжилга ардын хамт зарлигаар уул хошуунаас шилжүүлж их шавьд захируулсныг хичээнгүйлэн дагаж тэдгээр тайж ардын өрх ам хөрөнгө малыг нэг нэгээр байцааж ирүүлмөй⁴ хэмээжээ.

Мөн отгийн тоо олширч байгаагийн нэгэн шалтгаан нь: 1914 онд Их шавиас төрд ажиллах хэргэмтэн лам нарт хар ноёдын адил хамжлага олгож отог байгуулж өгсөн явдал байв. Тухайлбал: ...Харъяат шавийн шинэ дутам Ван гүний хэргэм шагнагдсан Эрдэнэ шанзудба Бадамдорж, Чин Сүжигт лам Цэрэнчимэд Да лам Дашжав мөн гүн лам Осор нарын зэрэг хүнд отог шавь хамжилга нарыг тасалж олгож хэмээгээд

- Сайд Эрдэнэ шанзудба Хүжир хамба Чин зоригт Жүн ван ламд өрх 40, ам 228, тэмээ 8, адуу 299, үхэр 269, хонь 1268 үүнд онуулсан сэвэг 7, сул 265 хэмээжээ.
- Сайд Да лам Чин сүжигт Чин ван лам Цэрэнчимэдийн хамжилгад өрх 32, ам 293, хөрөнгө нь тэмээ 79, адуу 226, үхэр 178, хонь 2155, оногдох сэвэг 9, сул 290 хэмээжээ.
- Билэгт нэнсү гүн лам да ламын хамжилгат өрх 25, ам 118, хөрөнгөний

¹ МУУТА. А-3, Д-1, Хн-80, 222

² МУУТА. А-74, Д-1, Хн-509.

³ МУУТА. Х-179, Д-1, Хн-262, нугалбар 9.

⁴ МУУТА. А-74, Д-1, Хн-928, нугалбар 5.

тэмээ 19, адуу 165, үхэр 123, хонь 970, оногдсон сэвэг 3, сул 610

- Нягт билэгт гүн Дам ламын хамжилгат өрх 16, ам 82, тэмээ 13, адуу 42, үхэр 121, хонь 695 оногдох сэвэг 3, сул 200¹ гэж дурьдсан байх юм.

Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт эдгээр отог шавь нарыг Их отгийн тоонд оруулсан байдаг.

Энэ мэт шалтгаануудаар Монгол улсын хаан VIII Богд Жибзундамба хутагтын шавьд орох явдал их байснаас 1912 оны байдлаар 6078 өрх, 36668 амтай байсан бол 1915 оны тоогоор 6654 өрх, 38645 ам, 1918 он 10724 өрх, 58168 амтай болсон нь 1912-1915 онд их шавийн өрх 8,7%-иар, хүн ам 5,2 %-иар нэмэгдсэн бол 1915-1918 өрх 16,2%, ам 15% өссөн байна.

Эдгээр шинэ, хуучин шавь нарын үндсэн үүрэг нь дээр өгүүлсэн тахилын цай барих билээ. Иймээс 1915 онд шавь ардуудын хөрөнгөнд тахилын цайны алба оноосон байдлыг шинжлэн үзвээс: Их, бага нийлсэн 154 отгийн 11330 алба баригч шавь нарыг дотор нь:

- Баян чинээлэг малчин өрх

Дээд тал нь 3 сэвгийн алба барих чадвар бүхий 8 өрх байна. Ойролцоогоор 700 орчим тоо толгой малтай. Тухайлбал: Баруун хүрээний хуврага Лхамсүрэн --- хувраг 7, өрх 1, ам 8, тэмээ 48, адуу 291, үхэр 52, хонь 311 сэвэг 3, сул 760² хэмээн алба тогтоолгожээ.

Энд: 3 сэвэгээс 100 сэвэг бүхий малтай өрхийг баялаг малтайд тооцвол 1309 малчин өрх хамрагдаж байна.

- Татвар төлөх чадвар бүхий өрх

100-50 сэвэг бүхий малтай өрхүүдийг 1408 өрх

- Амьжиргааны малтай багахан татвар төлөх ядуу өрх

50-иас доош \45-10\ сэвэг бүхий малтай өрх гэж үзэж болно. Цөөн хэдэн амьжиргааны малтай 4115 өрхүүд юм. Тэр дундаа 10-аас доош сэвэг малтай 2118 өрхийн тоо бүртгэгдсэн байна.

- Огт малгүй өрх

4458 өрх огт малгүй хэмээн бүртгэгдсэнээс үзвэл Их шавийн өрхийн 2717 буюу 31% өрх алба барих чадвар бүхий бол 8573 өрх буюу 69% алба барих чадвар үгүй болон бага хэмжээний алба барих ядуу өрхүүд байна.

Шавийн ам, өрх малын тоог хүснэгт 2-т үзүүлсэн дотроос 1918,1924 оны баримтыг харьцуулан үзвэл

¹ ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Түүхийн баримт, мэдээллийн төв. Ф-1, Т-1, Хн-35.

² МУУТА. А-74, Д-1, Хн-313.

Хүснэгт 3¹ Их шавийн хүн ам, өрх малын тоо

Он	Өрх	Хувраг	Ам	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Нийт
1918	10724	23903	58168	36030	6448	31078	137747	211303
1924	13449	24595	86631	186671	31715	246247	1218330	1682963
Нийт малын тооны өсөлт	2725	692	28463	150641	305267	21516	1080583	1471660

Энэ 2 онд 1 сая 471660 тоо толгойгоор нэмэгджээ. Энэ нь 1921-1924 онд Жибзундамба хутагтын мал огцом өссөн гэсэн үг биш юм. 1915-1920-иод орнуудад болсон улс төрийн олон үйл явдал, харийн түрэмгийлэл зэрэгт сан шавь хоосорч алба бариж чадахгүй хүрээв хэмээсэн олон баримт байдаг. Дурдвал: *...шавь нар нийтээр чинээ ядуурсан бөгөөд цагийг дагаж аливаа зүйлийг арвилан хэмнэвээс зохих учрыг ван гүн лам нарын хамжилгыг олгуулахад ихээхэн цайтайг хасан гаргаж бага цайтай ба огт цай үгүйг нь нэр заах...*² гэх мэт олон баримтууд байдгаас үзвэл малын хорогдол их байсан байдаг. Тухайлбал: 1918 онд шавийн үндсэн 162 отогт 201920 мал тоологдож байсан бол 1921 онд 149 отогт шавь нарын 56108 мал буюу 27% -иар хорогджээ. Жишээ нь: Чандман отог 1918 онд хуврага 123, өрх 25, ам 228, тэмээ 22, адуу 196, үхэр 259, хонь 1756, нийт сэвэг 8, сул цай 70³ байсан бол 1921 онд хуврага 113, өрх 26, ам 230, тэмээ 22, адуу 74, үхэр 48, хонь 362, сэвэг цай 2, сул цай 70⁴ болтолоо буурсан байна.

1921 онд Ардын засаг төрийн эрхэнд гарч олон шинэчлэлийн үйл ажиллагаа хийсэн билээ. Тэрхүү ажлын нэг нь улс орон даяар малын үнэн зөв нарийн тоог гаргах гэсэн ажил байсан. Энэ ажиллагаагаар Жибзундамба хутагтын бүх отог, багийн малын тоог мал тус бүрд нас, насаар нь нарийн гаргуулж авсан байдаг. Энэ тоо дүн нь 1 сая 682963 тоо толгой малтай гэсэн дүн тоо гарчээ. Ийнхүү хэт өсөлттэй тоо гарахад олон хүчин зүйл нөлөөлсөн болов уу. Тухайлбал: 1913 оны байдлаар Их санд алба бариваг үгүй олон ямбаган хутагт хувилгаан, лам нар албан тушаалтан 155 хүн байжээ. Энэ тухай дор өгүүлэх болно. Эдгээр хутагт хувилгаад, албан тушаалтны хувийн мал сүргийн тоо толгой малын тоо нэмэгдэхэд тодорхой хувиар нөлөөлсөн. Жишээ нь: Манзушир хутагт Цэрэндоржийн хувийн 4 зүйлийн мал 5070-ийг 45 нэр өрхөөр маллуулж⁵ байжээ. Мөн албанаас зайлсхийн малаа нуун дарагдуулсан, Нийслэл хүрээнд очиж суусан зэргээс малын бүрэн тоо гарах боломж хаагдаж байжээ гэж үзэж болох юм. Гэсэн хэдийч 1 сая 471660 тоо

¹ МУУТА. А-74, Д-1, Хн-510, А-74, Д-1, Хн-509, Хн-179, Д-2, Хн-163.

² ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн. Түүхийн баримт, мэдээллийн төв. Ф-1, Т-1, Хн-36

³ МУУТА. А-74, Д-1, Хн-508.

⁴ МУУТА. А-74, Д-1, Хн-662.

⁵ МУУТА. Х-238, Д-1, Хн-8.

толгойгоор мал нэмэгдсэн шалтгааныг хүн ам, малын тоо бүртгэлтэй холбон үзлээ. Жибзундамба хутагтын шавийн хүн ам, малын тоо бүртгэл олон оны данснууд (1772-1924он) МУУТА-т хадгалагдан байна.

Энэхүү өгүүлэлд 1912-1924 оны тооллого данснуудыг ашигласан. Өөрийн үзсэн баримтуудын хүрээнд дүгнэлт хийхэд эдгээр бүртгэл баримтууд шавийн харьяатын болон малын тоог бүрэн илэрхийлж чадах баримт биш. Харин энгийн шавь нарт алба онуулсан данс болов уу хэмээн үзлээ. Алба онуулсан данс гэж үзэх нэг нотолгоо нь малын хөлөөр бодсон цайны тоог өрх бүрт жишээ 30,40,45 гэсэн тоогоор бичигддэг 37,39 гэх мэт тоо бичвэр байхгүй. Жишээ болгон үзсэн 1915 оны баримтад алба баригч 111330 өрхөөс 4458 нь огт малгүй, 10 сэвгийн алба барих 1563 өрх (10 сэвэг гэдэг нь 5 хоньтой эсвэл 1 морь, 2 хоньтой тэнцэх-Г.Б) байна. Энэ нь боломжгүй мэт санагдаж байна. Иймээс уг тоо бүртгэл данснуудыг алба оноосон данс гэж үзэн 5 хоньтой айлаас алба татах биш энэ нь 5 хонины алба барих боломжтой, огт малгүй хэмээсэн өрхүүд нь малгүй биш амьжиргааны цөөн малтай алба барих боломжгүй өрхүүд гэж үзэж байна. С.Пүрэвжав XIX зууны үед хутагт хувилгаадын ихэнх шавь нар 20 хонь тутам 1 хонь¹-ийг албан авдаг хэмээн бичжээ. Энэ жишээгээр үзвэл 10 сэвгийн алба барих өрхийн малыг хонь гэвэл ойролцоогоор 100 хоньтой айлаас 5 хонийг албанд авдаг гэж харж болох юм. Мөн Ш.Нацагдорж 20 бодын хөрөнгөтэй өрхөөс 50 цайны алба авах нь доод хэмжээ² хэмээн бичжээ. 20 бодыг XX зууны эхэн үеийн цайн ханшаар бодвол үхэр, адуу 1 бүр 8 сул цайтай дүйцнэ. Нийт 160 сул цайнаас 50 цайг татвар өгнө гэвэл 20 малын 6 татварт авна гэсэн үг юм.

Энэ бүгдээс харвал 1921 оныг хүртэл Их шавийн Эрдэнэ шанзудбын яам нь алба оноох нарийн журамтай байжээ. Гэхдээ Их сан шавь нарын алба барих журам гэсэн утгатай баримт бичгийг олж үзээгүй болно. 1924 оны мал сүрэг, өрх амын тооллого нь Жибзундамба хутагтын шавийн бодит малын тоо толгой юм.

Шавь нарын нийлүүлэх албаны тухай

Шавь нарын үндсэн үүрэг нь Жибзундамба хутагтын болон харьяа сүм хийдүүд, шавийн захиргааны зардал хэрэглэлийг гаргах явдал байв. Шавь нарын нийлүүлж байсан албыг тогтмол барих алба, тодорхой цагт барих алба гэж хоёр хувааж үздэг. Тодорхой цагт барих албаны тухайд судлаачид нэлээдгүй бичсэн

¹ Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. Улаанбаатар: 1978, 193

² Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 206

билээ. Тухайлбал: Жибзундамба болон бусад хутагт хувилгаадыг тодруулах, ширээнд залах, насны ой, таалал төгсөх, хайлан хурлууд, орд сүм шинээр барих, засах гэх зэрэгт Халх дөрвөн аймаг, шавь нийтээр зардал хэрэглэлийг хуваан гаргадаг байжээ.

Иймээс энэ удаа Жибзундамба хутагтын шавь нарын тогтмол барих албаны тухай тодруулахыг зорилоо.

Тогтмол албыг бидний хэлж заншсан ёсоор тахилын цайны алба гэж ерөнхийд нь нэрлэдэг. Ш.Нацагдорж *Шавийн ардуудын албыг хошууны адил бодоор биш цайгаар оноодог учир тахилын цайн алба гэж нэрлэдэг¹ хэмээжээ. Эрдэнэ шанзудбын яам алба хураах тогтсон журамтай байжээ. Тогтмол алба гурав, гурван жилээр хүн ам, өрх, малын тоо бүртгэлийг явуулан өрхийн малын хөлд дүйцүүлэн сэвэг, сул цайд бодож алба онуулахыг хэлнэ. Эдгээр албатай холбоотой олон оны баримтууд МУУАТ-т хадгалагдан байна. Тухайлбал, Олноо Өргөгдсөний 5(1915) онд байцаасан бүгд шавь нарыг малын хөлөөр онуулан хуваасан тахилын цай бүгдийн товч данс² зэрэг болно. Энэхүү сурвалж бичгүүдээс хутагтын харьяа сүм хийдүүд, Их шавийн харьяа хутагтуудад хэчнээн төрлийн алба барьдаг, албанаас чөлөөлөгдөх явдал, ядуурсан отог багийн ардыг хагас болон бүтэн албанаас чөлөөлөх, улсын чанартай өртөө, хулгай худал, отог хоорондын шилжилт хөдөлгөөн гэх зэрэг олон асуудлыг тодруулах бололцоотой юм.*

Албыг: Тахилын цай тэргүүнтэй Зулын шар тос, Саалийн үнээ, Дагаварын мөнгө зэрэг 6 зүйлийн үнээ, Зоог тахил ба хурал номын элдэв албаны хэрэглэлд хураах мөнгө хэмээн ерөнхийд нь хуваадаг байжээ. Даншигийн мөнгө, Зоог тахилын алба дотроо мөн хуваагдана. Энд: Түмэд хангалын аарц, Зулын 25-ны манз, сүү, Ерөөл, Ганжуурын хэрэглэл, дагаварын мөнгө, хар мод, нарс мод, өвс зэргийг багтаан алба онуулдаг байжээ. Тухайлбал: *1921 онд 160 отгоос 260 сэвэг 743 сул цай, тос 159201 жин, саалийн үнээ 936, даншигийн мөнгө зэрэг 6 зүйлийн үнэд 194322 цай, зоог тахилын хэрэглэлд 239752 мөнгөний алба³ тогтоожээ.*

Жишээ нь: *Эрдэнэ номун ханы отгийн тахилын цай 6 сэвэг 480 сул цай, 4184 жин тос, 35 үнээ, даншигийн мөнгө 5230 цай, зоог тахилын хэрэглэлд 8448 лан мөнгө барих бол Номч номун ханы отог тахилын цай 0, сул 435, тос 384, үнээ 3, дагварын мөнгө 480 цай, зоог тахилд 832 лан мөнгө⁴ -ний алба барих үүрэг*

¹ Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/*. Улаанбаатар: 1978, 226

² МУУТА. А-74, Д-1, Хн-328

³ МУУТА. А-74, Д-1, Хн-665

⁴ МУУТА. А-74, Д-1, Хн-665

хүлээж байсан бол баялаг малтай нэг өрхийн алба оноолтыг жишээ болгон үзэе. Загцал багийн ...хуврага Жамъяан 5 амтай тэмээ 25, адуу 203, үхэр 76, хонь 337 буюу 3 сэвэг цайг албанд өгөх бол дээр нь 6 зүйлийн үнэд 2400 цай, зоог сүү 36 жин, бүтээлийн аарц 24 жин, шар тос 454 жин, дагаварын биеэр мөнгө 95 лан 2 цэн мөн мөнгөнөөс 94 лан 8 цэнг шууд онуулсан нарс 79 тэрэг болмой. Жич сангийн адуун сүрэг хариулсан учир уул мөнгөнөөс 50 ланг хугачив ¹гэх мэтээр айл өрхүүдэд алба оноодог байсан байна.

Шавь нарын барих эдгээр албыг

- Үндсэн барих алба: тахилын цай өмнө өгүүлснээр бүх сүрэг малын тодорхой хувьд алба тогтоолгон барих.
- Биетээр барих алба: тос, үнээ, сүү, аарц, өвс, түлээ мод, лан мөнгө зэрэг албыг мал сүргийн ашиг шимээс, бусад гэж хуваан үзэж болно.

Эдгээр албыг цайд дүйцүүлэн бодож хураан авдаг байв. Тухайлбал: 1915 онд 1 сэвэг цайд 220 жин тос, 1 сэвэг цайд 2 лан 4 цэн мөнгө үүнээс лан бүрийг 150 цайд бодож хураана. 1 сэвэг цайд 9 үхэр түлээ үүнээс үхэр бүрийг 30 цайд бодож хураана. 9 сэвэг цайд 1 тэрэг өвс үүнээс тэрэг бүрийг 90 цайд, 1 сэвэг цай, 1 сэвэг цайд 15 жин сүү жин бүр 4 цай, 1 сэвэг цайд 3 жин аарц үүнээс жин бүр 4 цай, түмэд хангал ба цагаан цавын аарц 1 сэвэг цайд 12 жин үүнийг жин бүрийг 4 цайд хураах, зулын 25-ны манз, сүү 1 сэвэг цайд 10 жин үүнийг жин бүрийг 4 цайд бодож хураана, 1 гахайд мөнгө 25 лангаар суутгаж хураах, дагаварын мөнгө 1 сэвэг цайд 400 лан үүнийг цай бариваас цагийн үнээр бодож хураамой, саалийн үнээ жилд 300 нийт 900 нэг үнээ 470 сул цайтай ² тэнцэнэ хэмээжээ. Жишээ: Эрдэнэ номун хан Дамбажавын отог³ Тахилын цай 6 сэвэг 480 сул цайны алба барих ба 4184 жин тосыг 19 сэвэг цайд, үнээ 35-ийг 20 сэвэг, 562 сул цайгаар дүйцүүлэн бодуулж санд хураалгаж боломжтой гэсэн үг юм. Дархадын зэрэг хол нутагтай отог багууд аарц, сүү, үнээ, тос зэрэг албыг цайгаар, мөнгөөр тушаан хүргүүлдэг байсан болов уу.

Эдгээр отгууд энэхүү албыг 3 жилийн дотор бариж дуусгах журамтай. Отог багуудаас жил дутам бариж байсныг илтгэх олон данснууд байдаг. Тухайлбал: 1860 онд тахилын цай, тосны албыг 9-4 отог нийлэн 1 сард ойролцоогоор 110 сэвэг, тос 2500 жин орчмыг санд барьдаг байжээ. Жишээ нь: Их барга, Мэргэн, Эрдэнэ хувилгаан, Дархан, Цагаан хөхөлийн отгууд Сэвэг 110, сул цай 130, жин

¹ МУУТА. А-74, Д-1, Хн-246, 78

² МУУТА. А-74, Д-1, Хн-328

³ МУУТА. А-74, Д-1, Хн-513

тос 2644 тушааснаас *Их баргын зайсан дарга Балдандоржийн отог сэвэг* 49, сул 520, жин 119, бан 1 тосыг¹ тушаажээ. Мөн *Нийслэл хүрээнд жил бүр зуны сүүл сард хурдаг 6 өдрийн ганжуур, 3 өдрийн бүтээл хурахад*² бүх отог багууд 13 өдөрт хуваагдан ном хуруулжээ. *Жишээ нь: 1 дэх өдөр Тойдууд тэргүүнтэй 10 отог нийлэн 50 сэвэг 281 сул цайны алба барьсан байна. Хуралд өдөр бүр хэрэглэх зүйлийг төсөвлөн гаргаж ...шар тос 248 жин, аарц 4349 жин, сүү 4182 жин, түлээ 94 тэрэг...* болно ... үүнийг харьяа дарга, мэдээч нар өөр өөрийн отог багын оногдол цайны их бага харилцан түүгээр хэлэлцэж уг хэрэглэх зүйлийг аль бэлэн буйгаар нийлүүлэн гүйцэтгүүлж тухай бүрд орсон юмсыг үнэ цай бодож тэгшитгэн хуваа³ зэргээр гаргуулсан бол 1921 онд зоог саалийн үнээг татахдаа нэг зүг дэх отгууд нийлэн саалийн үнээг Нийслэл хүрээний газар хүргэн ирдэг байжээ. *Баруун өмнө зүгийн Эрхэм отог 5, мөн 2, Чандман 10, Хүжиг 17, Алтанбулаг 3, Эрхтэн 1 зэргээр нийт 38 үнээ⁴ гэх мэт. Бусад албыг энэ маягаар гүйцэтгэж байсан байна.*

Энэхүү ажлыг зайсан дарга, шүүлэнг, мэдээч хариуцан хүлээн авч Эрдэнэ шанзудбын яаманд тушаах үүрэгтэй байсан байна.

Их шавийн харьяа сүм хийдүүд ба албанаас чөлөөлөгдөх нь

Их шавь харьяа олон сүм хийд, шүтээн, хурлын газрууд үйл ажиллагаа явуулдаг байв. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг 34-р дэвтэр Лам нарын хуульд⁵ Жибзундамба хутагтын Их шавийн харьяа 50 орд, хурал, сүм, дацан, хийдүүдийн албан тушаалтны эрх үүргийг хуульчлан зааж өгсөн байна. Энэхүү олон сүм хийдийн зардлыг Их шавийн ардуудын тогтмол албанаас гарган бэлдүүлдэг байжээ. Отог багууд орон нутаг дахь сүм хийдийн зардлыг дангаар болон ойролцоо отог багаар хуваан нийлүүлдэг. 1913 онд Амарбаясгалант хийдэд тахилын цай, тос, сүү, түлээг *Тариачин 2 отог, Библиг, Орхон 2 отог, Сэлэнгийн 2 отог, Цэнгэлийн отгууд нийлэн 590 сул цай, тос 60 жин, сүүний үнээний цай 64, түлээний үнэ цай 197* гаргасан бол *Их дуганы хэрэглэлийг Хийдчин 2 отог, Хамниган отгууд 775 сул цай тос 60 жинг* ⁶*тус тус барих үүрэг хүлээжээ. 1921 оны тахилын цай бүгдийн дансанд өгүүлснээр 22 сүм хийд, 10 шүтээний газар, 1 дацан, 5 жасын хэрэглэлийг*

¹ МУУТА. М-85, Д-1, Хн-295

² МУУТА. А -74, Д-1, Хн-1626, нугалбар 1.

³ МУУТА. А-74, Д-1, Хн-1626.

⁴ МУУТА. А-74, Д-1, Хн-1573, нугалбар 1.

⁵ *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл.* Боть II. Улаанбаатар: 2010, 273-275

⁶ МУУТА. А-74, Д-1, Хн-152

бэлтгэн гаргажээ. Тухайлбал: Их баргын отог 200 сул цай, 13 жин тосыг Сажиньны бадруулагч хийдэд барих, Эрдэнэ номун хан Дамбажавын отогоос Эрдэнэ номун ханы хүрээнд хэрэглэх 30 сул цай 3 жин тос буй¹ гэх мэтээр сүм хийдийн зардал хэрэглэлийг отог багууд гарган нийлүүлдэг байжээ.

Их шавьд голын долоон хутагт тэргүүнтэй олон хутагт хувилгаад хурал номын үйл ажиллагаа явуулдаг байв. Эдгээр хутаг нар өөрсдийн харьяа отог шавь, хүрээ, сүм хийдийн үйл ажиллагааг эрхлэн мэддэг байжээ. 1913 оны нэгэн баримтанд өгүүлснээр *Их санд цай зүйл барьдаг үгүй дандаа хэргэлдэг эрхтэн лам нар Манзушир номун хан, Ноён номун хан, Эрдэнэ номун хан, Мэргэн хамба номун хан, Мэргэн номун хан тэргүүнтэй 22² лам байх бол Их санд алба барьдаг үгүй 30 албан тушаалт лам байв. Энд: Сайд Эрдэнэ шанзудба, Сайд чин сүжигт да лам, Дархан цорж Лувсандэндэв, цорж Цэрэнпил, Сажин бадрах хийдийн цорж Жамбал, Зүүн хүрээний цорж Соном³ гэх зэрэг эрх тушаалт лам нарыг албанаас бүрэн чөлөөлөгдөж байжээ.*

Мөн 8 зүгийн Бүгдийн дарга, дэд дарга, отгийн зайсан дарга, шүүлэнг, отгийн харьяат шавь нар Их шавьд алба хаагчид *...Бүгдийн дарга Намжилдэв, дэд дарга Сэдэд, Хэрлэнгийн зайсан дарга Содномдаржаагийн хуврага Сэрбазар⁴ зэрэг 103 хүнийг албанаас бүрэн чөлөөлсөн байна.*

Шавь нарт албанаас хагас чөлөөлөгдөх явдал цөөнгүй байжээ. Тухайн шавь язгуур угсаатай тохиолдолд албанаас тодорхой хувиар чөлөөлөгдөх явдал 1921 оны дансанд 28 байна. *...Чин зоригт чин ван ламын хамжилга гүн Гүрсэдийн 15 сул цайд ерөөл ганжуур, дан тахилын цай тос барина. ...Эрдэнэ хамба хутагтын шавь гүн Цэрэнбалжир 165 сул цайд ерөөл ганжуур тахилын цай тос дагаврын мөнгө барихаас өөр алба үгүй⁵ гэх мэтээр албанаас хөнгөлж байжээ. Мөн Их сангийн болон бусад мал сүрэг адуулсан шавь нар ажил хийж зарим албанаас чөлөөлөгдөх боломжтой байжээ. ...Улсын эх дагина таны Цэдэн-шийн отог Улсын эх дагины таны сүрэг адуулсан хуврага Жамцын 55 сул цайд дагаварын мөнгө барихаас өөр алба үгүй⁶ зэргээр тогтмол албанаас хагас чөлөөлөгдөх явдал гардаг байжээ.*

Отог багуудад ядууран албаа төлөх чадваргүй болсон үед 3 жилээр болон зарим

¹ МУУТА. А-74, Д-1, Хн-665

² МУУТА. А-74, Д-1, Хн-152

³ МУУТА. А-74, Д-1, Хн-152

⁴ МУУТА. А-74, Д-1, Хн-152

⁵ МУУТА. А-74, Д-1, Хн-665

⁶ МУУТА. А-74, Д-1, Хн-53

нэгэн албаас отгоор нь чөлөөлөх явдал нийлээдгүй гардаг байжээ. ...Сэлэнгийн дарга Мөрдэндэвийн отог хөрөнгө хохирсон учир оногдох бүх албыг бүрэн хугачих ...Далай хутагт отог Далай хутагт Лхарамбын дамжаа барихад хүчин чинээ хүрэлцэх үгүйд харъяат отгийн санд барих албанаас ...энэ 3 онд баривал зохих албан дотроос шар тос 300 жин, дагаварын мөнгө 300 лан хугачив¹ гэх зэргээр албанаас чөлөөлөх явдал их гардаг байжээ. 1921 оны байдлаар их шавьд алба баригч 11223 өрх² байсны 1 сэвгийн алба барих хөрөнгө бүхий 8 өрх, 799-100 сул цай алба барих 439, 95-50 сул цай 644, 45-10 сул цай 3889, тахилын цайны алба барих чадвар үгүй 6217 өрх байна. Нийт алба баригч өрхийн 55% нь алба барих боломж үгүй өрхүүд байгаагаас хархад отгийн оногдол албыг алба төлөх боломжтой цөөн тооны өрхүүдийн төлдөг байжээ. Алба барих чадваргүй өрхүүдийг Эрдэнэ шанзудбын яамнаас албанаас чөлөөлөх, хагаслаж алба оноох, огт малгүй өрхүүдийг сангаас тэнхүүлэх зэрэг олон ажлыг хийдэг байсан бололтой.

Дүгнэлт

Халхын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагт нь ард олны оюун санааг эзэмдэгч байснаар, анхан дүрээс VIII дүр хүртэл түүний харъяат болох хүсэл ард олны дунд их байжээ.

Жибзундамба хутагтын Их сангийн хүчин чадал нь харъяат шавь нарын үндсэн хөрөнгө болох малын тоо толгойтой нягт холбоотой байсан. Гэсэн хэдий ч шавь өргөгдсөн ардад баян чинээлэг гэр бүл цөөн тоотой байв. Энэ нь хошуу засгууд өөрийн хошууны баян чинээлэг хүмүүсээ шавь алдах хүсэлгүй, Чин улсын төрөөс ч сум эр, хар ардыг шавь болгохыг хориглож байснаас ихэнхдээ ядуу хоосон, лам хүмүүс шавь болох явдал их байжээ. Их шавьд ядуу өрхүүд их байсныг 1915, 1921 оны данс харуулж байна. Эрдэнэ шанзудбын яамнаас дээрх хоосон ядуу өрхүүдийн амьжиргааг сайжруулах арга хэмжээг авдаг байсан байна.

Хутагтын сангийн нэг их үүсвэр нь сүсэгтэн олноос өргөж байсан сүрэг мал юм. Энэхүү хуримтлагдсан малыг Эрдэнэ шанзудбын яам хоосон ядуу шавь нарт таслан өгч малжуулан амьжиргаа сайжирсан үеэс алба оноодог байсан бололтой. Энэ нь Эрдэнэ шанзудбын яам хоосон ядуу хүмүүст нэг талаар ажил олгогч болох, нөгөө талаар эдгээр шавь нарыг Их санд ажиллах хүч болгон ашиглаж байсан гэж хэлж болох юм.

¹ МУУТА. А-74, Д-1, Хн-53

² МУУТА. А-74, Д-1, Хн-662, 663.

Эрдэнэ шанзудбын яамнаас шавийн хүн ам, өрх, малын тоо бүртгэлийг 3 жилд нэг удаа явуулан үндсэн хөрөнгөнд дүйцүүлэн алба оноох ажлыг хийдэг байсан. Үүнийг илэрхийлсэн он оны тоо бүртгэл данс байдаг билээ. Уг баримтуудыг өмнөх судалгаанд Жибзундамба хутагтын шавь нарын өрх, ам, малын тоо бүртгэл данс хэмээн үздэг байсныг өөрийн судалгаагаар энэхүү баримтууд нь Их шавийн өрхүүдэд алба оноосон бүртгэл данснууд юм. Эдгээр баримтууд нь Их шавийн хүн ам, өрх, малын бүрэн бүтэн тоог харуулах боломжгүй баримтууд хэмээн үзсэн болно.

Энэхүү алба оноох данс бүртгэлийн дагуу шавь нар Тахилын цай албыг Их санд заавал барих ёстой боловч бүх шавь нар энэхүү үүргээ биелүүлж чаддаггүй байсан байна. Их шавь хошуудаас ялгаатай нь алба тогтоохдоо малын тоо толгойг цайгаар дүйцүүлэн алба оноодог байснаас бүх албыг Тахилын цайн алба хэмээсэн буруу ойлголт бий болсон байв. Тахилын цайны алба бол их шавийн ардуудаас Их сан барих албаны нэг төрөл байжээ.

Abstract: The tea office's primary responsibility was accounting and taxing the spending of the peasants who are subject to the Buddhist leader of Khalkha Bogd Jibzundamba hutagtan and monasteries. Therefore, in this article, it is possible to find out information on operations of Erdene shanzubd's ministry which is under control of the Bogd Jibzundamba hutagtan from the Mongolian National Central Archives. The tea office's activities include establishing tribute requirements for the Treasury, and it is specifically active in the matter of collecting tribute from the peasants. Information on how much the peasants had, what have been collected and how much have been given can be found on material in The Mongolian Central Archives. While peasants mostly had few stock animals and wealth, the information obtained by Erdene shanzundbin's ministry every tree years on subject peasants is not a source that can adequately reflect the demographics of the general populace and number of the stock animals belonging to the wider population. It is better to be considered as a source for getting information on accounting and tributes on the peasantry. According to this, the tea office's primary responsibility collection of tributes from the peasants. The office consisted of two parts the tea office and the animal production collecting office. The treasury depended heavily on the wealth of the peasantry.